

## МОНГОЛ-БРИТАНИЙ ХАРИЛЦААНЫ ТҮҮХЭЭС

*Д.Золбоо\**

Энэ жил Монгол-Британий хооронд албан ёсны харилцаа тогтоосны 40 жилийн ойг хоёр тал нэлээд өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүллээ. Дэлхий дахинаа United Kingdom буюу Нэгдсэн Вант улс нэрээр хэвшин тогтсон энэ улсыг бид олон талаар мэдэх билээ. Хоёр талын хамтын ажиллагаа, харилцааны тухай ч сүүлийн үед өдөр тутмын тогтмол хэвлэл болон судалгааны сэтгүүлд нэлээд хэдэн бүтээл гарч судлаачид ч өөрийн хувь нэмрээ оруулсаар байгаа билээ. Манай хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын гүйцэтгэж байгаа “АНУ, Өрнөдийн орнуудаас Монголд явуулж байгаа бодлого” сэдэвт судалгааны ажлын нэг хэсэг нь “Монгол-Британийн харилцаа, Британиас Монголд явуулж буй бодлого” гэсэн нэртэй бөгөөд энэ ажлынхаа хүрээнд энэхүү цуврал өгүүлийн эхний хэсгийг танд хүргэж байна.

Төв Азийн цээжинд төр улсаа байгуулан мандан бадарч байсан нүүдэлчин улс гүрнүүдийн түүхэнд, тэр дундаа Чингис хаан болон түүний дараагийн Их Монгол улсын үед гадны улс гүрний хаад, ноёдод албан бичиг, захидал илгээх, гадаад орны элчин төлөөлөгч хүлээн авч, харилцаж байсан баримт олон байдаг билээ. Хэдийгээр Британ нь эртний түүхт улсуудын нэг боловч манай хоёр орны хувьд албан ёсны харилцаа ХХ зууны эхнээс улбаатай болов уу. Манай түүхийн баримт бичгүүдэд 2 орны харилцааны талаар тэмдэглэсэн архивын баримтаас сөхөн сонирхуулахыг зорилоо.

ХХ зууны эхэнд үндэсний эрх чөлөөний хувьсгалаар олж авсан тусгаар тогтнолоо албан ёсоор тунхаглаж хоёр их хөрш болон дэлхийн бусад хөгжингүй улсад явуулсан бичгийн эх хувь өнөөдөр Монгол Улсын үндэсний Төв Архивт хадгалагдаж байна.

Олноо өргөгдсний хоёрдугаар он буюу 1912 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн Монгол Улсын Гадаадын хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамны бичиг-т “*Их Фа, Инг, Дэ, Мэй, Билиши, Жи бэн, Дан мэй, Хе лан ану Улсын Гадаадын хэргийн явдлын яамнаа илгээв. Мэдтүгэй хэмээн явуулах учир* : ... (1) “гээд цааш нь тусгаар тогтнолоо зарлан тунхаглахын ялдамд хойшдоо харилцаа холбоотой байхыг хүсч байгаагаа илэрхийлсэн байна. Гэвч харамсалтай нь дээрх Франц, Британи, Герман, Америк, Бельги, Япон, Дани, Холланд гэсэн 8 улсын нэг нь ч хариу ирүүлээгүй (2) ажээ. Тухайн үеийн төрийн албан хэрэг

хөтлөлт болон номын мэргэдийн хувьд арай ойр байсны хувьд гадаад орны нэрийг хятад хэлний дуудлагаар буулгасан байна. Дээрх бичгийн 2-рт бичигдсэн Инг Улс (с, ying) гэдэг нь Британийг нэрлэдэг ханз үсгийн дуудлагын нэр юм. Харин хожим нь орос хэлний нөлөөгөөр монголчууд Британийг “Англи” гэж нэрлэж дадсан боловч энэ нэр нь Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсыг бүхэлд нь төлөөлүүлэхэд зарим нэг талаар боломжгүй билээ. United Kingdom of Great Britain and Northern Ireland (3) буюу Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс гэдэг нь тус улсын албан ёсны бүтэн нэр бөгөөд Британи буюу Нэгдсэн Вант Улс хэмээн товчлон нэрлэж заншсан байна. Британи буюу ИБУИНВУ-д Улсад Англи, Уэлс, Шотланд, Умард Ирланд багтана. Мөн зарим тохиолдолд орос хэлнээс “Велико Британия”(4) гэдгийн орчуулга Их Британи-ийг улсын нэрээр төлөөлүүлэн нэрлэдэг нь ч гэсэн ташаа ойлголт болно. Учир нь Их Британи гэдэг нь зөвхөн Англи, Уэлс, Шотланд орших тэрхүү арлаа нэрлэдэг нэр юм. (5) Иймээс цаашдаа албан болоод бусад зүйлд улсыг нь төлөөлүүлж ерөнхийд нь нэрлэхдээ Британи гэж хэлж заншвал зүйтэй болов уу.

1945 оны хоёрдугаар сард Ялтад болсон ЗСБНХУ, АНУ, Британи 3 улсын төрийн тэргүүнүүдийн дээд хэмжээний уулзалт, бага хурлын үеэр ЗХУ-ын санаачилгаар нөгөө хоёр талдаа Дэлхийн II дайны дараа Монгол Улсын статус-кво (байгаа байдлаар нь халгалах) –г хэвээр үлдээнэ гэдгийг хүлээн зөвшөөрүүлсэн (6) нь цаашдын харилцаанд томоохон байр суурь эзэлснийг хүлээн зөвшөөрөх бизээ. Хожим Бээжинд суугаа Британийн түр хамаарагчаас Бээжин дэх манай элчин сайдад 1962 оны 12 дугаар сарын 20-ны өдөр ноот ирүүлж, Монголын Улсын Засгийн газар хүсвэл, хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтооход бэлэн байгаа тухайгаа мэдэгджээ. Энэхүү ноотод дөрвөн заалт бүхий Меморандумыг хавсралт болгож ирүүлсэн байна. Дөрвөн хоногийн дараагаар буюу 1962 оны 12 дугаар сарын 24-нд энэ мэдэгдлийн дагуу тухайн үеийн улс төрийн тогтолцооны эрх барих дээд байгууллага МАХН-ны Төв Хорооны Улс Төрийн Товчоогоор уг асуудлыг авч хэлэлцээд 410 дугаар тогтоол гарчээ. Улс төрийн товчооны гишүүд Ц.Дүгэрсүрэн, Ю.Цэдэнбал, Л.Цэнд нарын гарын үсэг бүхий уг тогтоолд “*Их Британий Нэгдсэн Вант Улсаас тус хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоох асуудлыг санаачлан тавьж байгааг хүлээн авч, БНМАУ ба Их Британий Нэгдсэн Вант Улсын хооронд дипломат харилцаа тогтоохыг зөвшөөрсүгэй*” гэсэн байна. (7) Улмаар удалгүй 25 хоногийн дараа буюу 1963 оны 1

дүгээр сарын 18-ны өдөр Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 11 дүгээр зарлиг гарчээ. АИХ-ын тэргүүлэгчдийн дарга Ж.Самбуугийн гарын үсэг зурсан уг зарлигт “*Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Их Британи ба Хойт Ирландын Нэгдсэн Вант Улсын хооронд дипломат харилцаа тогтоож, Элчин Сайддын зэрэгтэй дипломат төлөөлөгчид солилцохыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд даалгасугай*” (8) гэсэн байна.

Ийнхүү дээд газрын шийдвэр гарсан учраас 1963 оны 1 дүгээр сарын 21-нд ИБУИНВУ-аас БНХАУ-д суугаа түр хамаарагч Бээжинд суугаа Монгол Улсын ЭСЯ-нд хүрэлцэн ирж, хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосон тухай биечилсэн ноотод гарын үсэг зурж солилцжээ. Ингээд 1963 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Улаанбаатар, Лондон хотуудад зэрэг мэдэгдэл хийснээр хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтсон түүхтэй ажээ. (9)

Монгол Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын хооронд тогтоосон энэхүү харилцааны нэг онцлог гэвэл Британи нь манайтай харилцаа тогтоосон 25 дахь (10) улс төдийгүй өрнөдийн өндөр хөгжилтэй орнуудаас хамгийн түрүүнд Монгол Улсыг хүлээн зөвшөөрсөн улс болсон ажээ. Британи Улаанбаатар хотод ЭСЯ-аа 1964 онд, Монгол Улс Лондонд ЭСЯ-аа 1969 онд тус тус нээсэн байна. Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад суух анхны элчин сайдаар Д.Балжинням /БНМАУ-аас БНПУ-д сууж байсан элчин сайд/, Британиас БНМАУ-д суух анхны элчин сайдаар Теренс Гарвэй / Бээжинд сууж байсан Британийн түр хамаарагч/ нар тус тус томилогдож байжээ.(11) Энэ хугацаанд нийт 10 элчин сайд ИБУИНВУ-д томилогдон ажиллажээ.

Дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр улсын харилцаа хэвийн хөгжиж байсан боловч тухайн үеийн дэлхий дахинд ноёрхож байсан “Хүйтэн дайн”-ны уур амьгал нөлөөлсөн нь мэдээж билээ. 1990 оноос хойш манай улсад өрнөсөн ардчилал, өөрчлөлт шинэчлэлийн үйл явц хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэн хөгжүүлэхэд таатай орчин бүрдүүлсэн. Манай улсын сонгосон ардчилал шинэчлэлийн үйл явцыг Британи эхнээс нь дэмжиж ирсэн бөгөөд үүний нэг тод жишээ бол 1991 онд Лондонд болсон “Их Долоо”-гийн уулзалтын мэдэгдэлд, манай орны улс төр, эдийн засгийн шинэчлэлийн ололт амжилтыг үнэлж, цаашид дэмжихийг уриалсан байна. Энэ утгаараа Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал болон Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт НҮБ-ын

санаачлан байгуулагч гол орны нэг, Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн, Европын Холбоонд нөлөө бүхий жинтэй, идэвхтэй бодлого явуулдаг ИБУИНВУ-тай тогтоосон харилцаа чухал ач холбогдолтой гэж үзэн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхээр заажээ. (12)

Энэхүү 40 жилийн хугацаанд хоёр талын хооронд албан ёсоор 6 гэрээ байгуулж байжээ. Үүнд:

1. Консулын конвенц - 1975 он
2. Эдийн засаг, үйлдвэр, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх Засгийн газар хоорондын хэлэлцээр - 1991 он
3. Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хамгаалах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр - 1991 он
4. Хөдөө аж ахуй салбарт хамтран ажиллах гэрээ - 1992 он
5. Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Засгийн газар хоорондын конвенц - 1996 он
6. Боловсрол, шинжлэх ухаан, соёлын салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр - 1996 он (13) зэрэг юм байна.

Дараа дараагийнхаа өгүүлэлдээ 2 талын улс төр эдийн засгийн хамтын ажиллагаа, харилцааны өнөөгийн төлөв зэрэг асуудлыг хамарсан мэдээллийг хүргэх болно.

### **Ашигласан материал**

1. Үндэсний Төв Архив, Түүхийн баримтын төв, сан хөмрөг А4, данс 1 хадгаламжийн нэгж 5
2. “Монголын түүхийн дээж бичиг” эмхтгэсэн Л.Жамсран, УБ, 1992
3. “The World Book Encyclopedia”, Ch, 1995
4. “Большая Советская Энциклопедия” т 7, М., 1951
5. “Монголын Нэвтэрхий Толь”, УБ, 2000
6. “Хорьдугаар зууны Монгол” Редактор М.Санждорж, УБ, 1995
7. Үндэсний Төв Архив, МАХН-ын баримтын төв х 4, д-26, хн – 3
8. Үндэсний Төв Архив, Орчин үеийн баримтын төв х 11, д-1 хн-1776
9. “Гадаад харилцаа” Монголын Улсын ГХЯ-ны мэдээллийн товхимол №3 (127)
10. Т.Нэргүй “Монгол, Британийн харилцаа” “Кэму” сэтгүүл, УБ, 2003
11. <http://www.extmin.mn/dipHariltsaataiOron.htm>
12. “Монгол Улсын гадаад харилцааны Хөх ном”, УБ, 2000
13. “Монгол, ИБУИНВУ-ын хооронд харилцаа тогтоосны 40 жилийн ойд”, Зууны мэдээ сонин, 2003.1.14-ний 11-р